



“ЗӨВ ДАДАЛ, ЗЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ, НОГООН ИРЭЭДҮЙ” АЯНЫ ХҮРЭЭНД
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР 425
ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН



Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас
зохион байгуулж буй аянд нэгдлээ

Манай анги, байгууллага дээрх аяны хүрээнд доорх ажлуудыг
хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нийт албан хаагч болон хорих ял эдэлж байгаа хүмүүжигчдийн
дунд “Хог хаягдлын тухай хууль”-д тусгагдсан иргэний эрх, үүргийн
талаар болон байгаль орчиноо хайрлах, хог хаягдлаа ангилан
боловсруулах, байгальд ээлтэй дадал хэвшил бий болгохыг
уриалсан сургалт, яриа таниулга хийлээ.





2. Ангийн “0425 радио, студь”-ийг хаягдал өндөгний хайрцаг ашиглан
тохижуулсан.



3. Мөн хүмүүжигчдийн дунд байгаль эх дэлхийгээ хайрлан
хамгаалах, хог хаягдлаа ангилан ялгах, дахин ашиглах чиглэлээр
зерэг нөлөөлөл үзүүлэх зорилготойгоор шинээр ажлын байрыг бий
болгон хуванцар сав бусад хог хаягдлыг ялгуулан одоогоор 7000
гаруй сав цуглуулан тэдгээрээр бүтээл хийх, худалдан борлуулан,
эргэлт уулзалтгүй 34 хоригдолд сургалтын хэрэгсэл авч
хүмүүжигчдийг соён гэгээрүүлэхэд ашиглаж байна.



4. Мөн байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдол болон хог хаягдлыг бууруулах ажлын хүрээнд ундааны бөглөөг цуглуулан өнгөөр ялгах, оршдоггүй амьтан бүтээлгэх зэрэг нь сэтгэл зүйн тайвшрал өгч стресс, уур бухимдалаас ангижруулах эерэг үр нөлөөтэй байна.



5. Говьсүмбэр аймгийн ойр орчмын хогийн цэгээс барилгын хаягдал материал болох төмөр, блок зэргийг цуглуулан шинээр баригдаж буй “Хүний хөгжлийн төв”-ийн хаалгыг босголоо.



6. Ногоон байгууламжийг бий болгох ажлын хүрээнд хорих ангийн дотор болон гадна талбайд жил бүр моджуулалт хийж, цэцэг тарих, хүлэмжинд өргөст хэмх, помидор, салатны навч, төмс, нарийн сонгино зэрэг хүнсний ногоо тариалж дотоодын хэрэгцээнд ашиглаж хэвшсэн. Одоогийн байдлаар алба хаагч хүмүүжигчдийн дунд уламжлалт намрын “ургацын баяр”-аа хийхэд бэлэн болоод байна.




7. Мөн удирдамжид тусгагдсаны дагуу байгууллагын дотор талд ангилан ялгах хогийн сав байршуулан нийт ял эдлэгсэд хог хаягдлаа ангилан ялгаж хэвшсэн байна.



8. Бусад төрлийн хаягдлыг хорих ангийн тохижилтод ашигласан нь



9. Хүмүүжигчдийн бүтээлч үйл ажиллагааг нэмэгдүүлэх, байгаль орчиндоо ээлтэй байх үүднээс гар бүтээл хийлгэж урамшууллаа.



9. Бөөрөлзгөнө жимсний мод тарьсан нь...



10. Мөн “Хог хаягдлын зааварчилгаа”, “Гэртээ хогоо хэрхэн ангилах вэ”, “Ногоон шошго”, “Уур амьсгалын өөрчлөлт нэвтрүүлэг”, “Байгалиа хайрлая” зэрэг сэдэвт видео болон бусад гарын авлага материалыг танилцуулах сургалтуудад албан хаагчдаа хамруулан ажиллалаа.



Уг аян нь хүмүүсийн дунд байгаль орчноо хайрлан хамгаалахад эерэг хандлага дадал зуршлыг идэвхижүүлсэн үйл ажиллагаа боллоо.

“ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЦГААЯ”

**ГСА ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР
425 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИ**